



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/182

Улаанбаатар хот

Нийтийн эзэмшлийн зам талбайг
чөлөөлж, түргэн үйлчилгээний цэгүүдийг
нүүлгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1, 27.4, 56 дугаар зүйлийн 56.5, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4, 59 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Б/34 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1261 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ард-Аюушийн өргөн чөлөөний дагуу Өргөө кино театраас И-Март худалдааны төвийн уулзвар хүртэлх хэсэгт явган, дугуйн зам шинээр барих болон засвар шинэчлэлт хийх ажлын нөлөөлөлд өртсөн 23 ширхэг Түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсүгэй.

2.Нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Эрдэнэчимэг), Газар зохион байгуулалтын алба (Д.Энхтөр)-нд, Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний ажлыг Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ (Ж.Галтбаяр)-т, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Г.Мөнх-Эрдэнэ)-т, шинээр Түргэн үйлчилгээний цэг байршуулахгүй байх ажлыг 13 дугаар хорооны Засаг дарга (У.Сүхбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Албадан нүүлгэж газар чөлөөлөөхөд шаардагдах 4 350 000 (Дөрвөн сая гурван зуун тавин мянга) төгрөгийн зардлыг Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний тасагаас гэрээ байгуулж гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Тамгын газар (Б.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.

4.Төрийн байгууллагын үйл ажиллагааг саадгүй явуулах, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (хурандаа Н.Сумъяа)-т үүрэг болгосугай.

5.Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдсэн буюу мэдсэн өрдөөс 30 хоногийн дотор нийслэлийн Засаг даргад гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ЖАРГАЛСҮРЭН